

УДИРДАМЖ

TEDxUlaanbaatar анхны ТАЙЗНЫ ЗАГВАР ЗОХИОН БҮТЭЭХ УРАЛДААНД бүтээлч хэн бүхнийг урьж байна. Тэмцээн бүх мэргэжлийн уран бүтээлч болон дизайн сонирхогч нарт нээлттэй бөгөөд ялагчийн загвараар **9-р сарын 13-ны** өдөр үйл ажиллагаа болох **Монголын Хүүхдийн Ордны** тайзыг засна.

TEDx арга хэмжээний талаар

TED нь “шинэ сайхан санаануудыг түгээн дэлгэрүүлэх” зорилгоор бүсчилсэн үйл ажиллагаа болох TEDx-ийг үүсгэн бий болгосон юм.

TEDx нь хүмүүс өөрсдийн туршлага, санал сэтгэгдлээ хуваалцдаг бие даан зохион байгуулагддаг TED-ын салбар арга хэмжээ юм. Бидний зохион байгуулж буй TEDxUlaanbaatar нь мөн адил бие даасан TED арга хэмжээ билээ. TEDxUlaanbaatar арга хэмжээний үеэр жижиг бүлгийн хүрээнд TEDTalks бичлэгүүд дээр тавигдсан асуудлууд болон илтгэгчдийн хөндсөн сэдвээр хэлэлцүүлэг явуулах юм.

Тэмцээний зорилго

TEDxUlaanbaatar үйл ажиллагааны 2014 оны арга хэмжээний тайзны загварыг шинэлэг, бүтээлчээр шийдэх болон бие даасан уран бүтээлчид, бүтээлч иргэдийн сонирхол, оролцоог дэмжих. Мөн уран бүтээлчдийг гарын доорх, өдөр тутмын бидний хог хаягдал болгодог материалыг дахин боловсруулж, бүтээлдээ ашиглахыг уриалж байна. Таны бүтээлч сэтгэхүйг, орчиндоо ээлтэй байдлаар дизайн гаргахыг манай багийнхан хүлээж байна.

Дүрэм

- Уралдаан хүн бүхэнд **нээлттэй**
- **Оролцогч** нь хувь хүн буюу 3-с дээшгүй гишүүдтэй баг, нэгдэл байх
- Тайзны загварыг гар доорх болон худалдан авах, ашиглах боломжтой/**дахин боловсруулах түүхий эдээр** бүтээх (Жишээ нь: пластик сав, лааз, шил, даавуу, мод,)
- Оролцогч **нэгээс олон** бүтээл ирүүлж болно
- **Ялагч** тайз бүтээхэд шаардагдах зардалын тооцоог гаргах ба шаардагдах түүхий эд бэлдэх, тайзыг засах ажилд биечлэн оролцоно. (Шаардлагатай бүх хөрөнгийг TEDxUlaanbaatar хариуцах ба тайз засахад хамтран ажиллана)
- Тайзны хэмжээс: Тааз – 12 м, Шал – 15 м, Өндөр – 11 м.

Шагнал:

Мэргэжлийн шүүгчдийн баг материалуудтай танилцан **ялагч** болон TEDxUlaanbaatar багийнхны **онцлох оролцогч** тус тус шалгаруулна.

Ялагч: TEDxUlaanbaatar үйл ажиллагааны өдөр тайзыг ялагчийн загвараар тохижуулан засах ба 1000000₮ үнэлгээ бүхий шагнал гардуулна.

Онцлох бүтээл: Багийн гишүүдээс санал аван, хамгийн бүтээлч, содон бүтээл ирүүлсэн оролцогчийг гарын бэлгээр шагнана.

Хугацаа:

Материал хүлээн авах: 2014.08.17-ийг дуустал

Ялагч тодруулах: 2014.08.24

Тайз засах: 2014.08.28 - 2014.09.10 хүртэл

Материал ирүүлэх:

Оролцогч нь “Уралдаан оролцох өргөдөл”-г онлайнаар www.tedxulaanbaatar.com хуудас руу орж бөглөх ба бусад материалыг design@tedxulaanbaatar.com хаягаар ирүүлнэ. Биетээр хүлээн авахгүй.

Явуулах материалууд:

1. Тайзны шийдлийн нийт элемент, харагдах хэсэг, шаардагдагдах зүйлсийг дүрсэлсэн **ерөнхий зураг** (2000×2000 pixels, 3 MB багтаана. JPG, RGB, (3D), гэх мэт)
 - Хүсвэл дурын програмаар бүтээсэн 3D загварчлал
2. Шаардагдах материалуудын **жагсаалт**, шаардагдах **зардал** (материалын болон барихад шаардлагатай зардал)
3. Өөрийн бүтээсэн загварын **танилцуулга**:
 - Загварын нэр
 - Загварын тухай Англи, Монгол хэл дээр бичсэн танилцуулга (500 үгэнд багтаана)
 - Тайзны загварын 3D хэмжээст зураг, загварчлал (ямар ч software ашиглаж болно. Жишээ нь: AutoCAD, SketchUP, 3D Max, Rhino гэх мэт. Хүсвэл гараараа зурсан зураг ч байж болно.
 - Зураг тус бүрийн хэмжээ ихдээ 2000×2000 pixels, 1 MB байх. JPG, RGB гэх зэрэг)
 - Энэхүү төслийн нийт дүрэм, шаардлагуудтай танилцсанг баталгаажуулан, гарын үсэг зурах: “Төслийн хүрээнд ялагчаар тодорсон тохиолдолд миний бүтээсэн загвараар TEDxUlaanbaatar арга хэмжээний тайзыг засахыг зөвшөөрч байгаа бөгөөд тайз засалд өөрийн биеэр оролцон, хамтран ажиллах болно.”
 - Мөн TEDxUlaanbaatar арга хэмжээний албан ёсны логог дизайн даа ашиглах боломжтой. Энэ бол оролцогчдийн сонголт. Санаа авах болон дизайн тал дээр юу анхаарахыг доорхи линкээс <http://www.slideshare.net/kenbautista/designing-your-tedx-stage> эсвэл google-ээс “tedx stage design” гэж хайхад бусад үлс оронд хийсэн тайзны засалтуудаас санаа авах боломжтой.

Сценограф

Сценограф бол театр, үзүүлбэрийн утга санааг илэрхийлж, сэдэвт нь төгс зохицсон уур амьсгал, орчинг бүрдүүлдэг элементүүдийн цогц юм. Үүнд: гэрэл, хөгжим, тайз зэрэг ордог. Уралдаанд ирүүлэх материалууд TEDxUlaanbaatar-н сэдэв болох “Удаахь Бүлэг” (“The Next Chapter”)-г илтгэх ёстой.

Сэдэв: “Удаахь Бүлэг”

Сүүлийн 20 гаруй жил Монгол улс олон сайн, муу өөрчлөлтүүдийн ард гарсаар ирлээ. Тэрхүү өөрчлөлтүүдийн дүнд, одоогийн Монгол дүр төрх, хэлбэрээ олсон. Итгэмээргүй хурдан өсөлт, нүд эрээлжилмээр олон өөрчлөлтүүдийн ард бид юуг мартана вэ? Бид нийгэм эдийн засгийн том том өөрчлөлтүүдийн гэрч нь болж, нарийн өргөн цариг, зэсийн үнийн уналт, ханшийн чангаралт зэрэг асуудлыг өдөр алгасалгүй ярьж, амьдрал зөвхөн энэ хэдхэн сэдэв дээр тогтдог шиг бүгд ам нийлүүлэн уралдан ярилцах. Хамгийн чухал яригдах сэдвүүд төдийлөн олны анхаарал татахгүй, ард үлдэн, улс төр эдийн засгийн огцом өөрчлөлтийн сүүдэрт мартагдсан мэт. Бидэнд үүнийг олж харж, өөрчлөх боломж болон цаг бий. ТЭДхУлаанбаатараар дамжуулан бидний мэддэг эсвэл огт мэддэггүй зүйлийг үйлдлээрээ үлгэр дууриалал болон үзүүлж буй

төлөөлөгч нарыг авчирахыг зориж байна. Эдгээр хүмүүсийн яриа, хийсэн бүтээсэн нь таньд нэгийг бодогдуулж, хараагүйг тань харуулж хийгээгүйг тань хийлгэх урам зориг, эрч хүч өгөх болов уу хэмээн энэ удаагийн арга хэмжээг “Удаах Бүлэг” хэмээн нэрлэсэн болно.

Монголын Хүүхдийн Ордны тайз:



Тайзны хэмжээс:

